**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ**

2020 оны 07 сарын 06 өдөр Дугаар 356 Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 7.2 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1."Эрдэнэт үйлдвэр төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 226,298,427.79 (хоёр зуун хорин зургаан сая хоёр зуун ерэн найман мянга дөрвөн зуун хорин долоон төгрөг далан есөн) төгрөгийн балансын үнэ бүхий 3 ширхэг автомашины ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлсүгэй.

2."Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрын ерөнхий захирал Х.Бадамсүрэн, "Баруун бүсийн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Р.Нямтуул, "Дорноговь-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал А.Баттогтох нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн шинэчлэн тогтоосон үнэ, хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Автомашины улсын дугаарыг бүртгэлээс шилжүүлсэн тодорхойлолт, арга хэмжээний биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Д.НАРАНГЭРЭЛ

0000788

D:\Huraldaanii material\2020 on\2020.07.06 11r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 07 дугаар сарын 06 өдрийн
356 дугаар тогтоолын хавсралт

## "ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

| д/д | Хөрөнгийн нэр | Ашиглалтад орсон огноо | Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг) | Шилжүүлэн авах хуулийн этгээд | Шинэчлэн тогтоосон үнэ (төгрөг) | Ашиглах хугацаа (жил) |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Ниссан Патрол 00-61 ОРХ, суудлын, арал-JN1TFSY61Z0559384 | 2010 | 100,000,000.00 | "Дорноговь АЗЗА" ТӨХК | 22,000,000.00 | 2 |
| 2 | Хьюндай Старекс 2096 ОРО, арал JN1TFSY61Z0559384 | 2011 | 42,964,575.00 | "Баруун бүсийн ЭХС" ТӨХК | 8,000,000.00 | 2 |
| 3 | Зил-130 АГП-22, авто өргөгч, 99-86 ОРХ арал дугаар-3478030 | 2004 | 83,333,852.79 | "Баруун бүсийн ЭХС" ТӨХК | 20,000,000.00 | 3 |
| | **Нийт дүн** | | **226,298,427.79** | | **50,000,000.00** | |
| | | | **(хоёр зуун хорин зургаан сая хоёр зуун ерэн найман мянга дөрвөн зуун хорин долоон төгрөг далан ес)** | | **(тавин сая)** | |